

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХОНГОР СУМЫН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2 ДУГААР
УЛИРАЛД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

Малчдын зөвлөгөөн зохион байгуулж малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах



Суманд “Малчдын зөвлөгөөн” 2018 оны 04 дүгээр сарын 27 –д зохион байгуулагдаж Хонгор сумын МАА салбарын өнөөгийн байдал, Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, мал эрчимжүүлэх чиглэлээр авч буй арга хэмжээний талаар, Монгол Улсад ажлын байр нэмэгдүүлэх хувийн хэвшлийн оролцоотойгоор мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн болон хүнсний ногооны үйлдвэрлэлийн нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх, Малын удмын сангийн үндэсний төвийн үйл ажиллагааны талаар мэдээлэл хийж, малчдын сонирхсон асуултад хариулж, малаа эрчимжүүлж, бэлчээрийн даацад тохируулах, малчдын орлогыг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах чиглэлээр уриалга гаргалаа.

Мөн сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Аймгийн Цагдаагийн газрын Малын хулгайтай тэмцэх хэлтэстэй хамтран Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт хийж малчдад “Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлцгээе” гарын авлага тараалаа.

Сумын цагдаа цагдаагийн дэд ахлагч Ж.Эрдэнэжаргал, Э.Тайванбаатар олон нийтийн цагдаа Б.Тамирбат нар Шийрийн бригад, Төмөр толгой,5,6 бригад, Хустайн даваа, Сонинхангай чиглэлд 8 удаагийн эргүүлийг шөнийн цагаар хийж сумаас гадгаш явж байгаа мал махан бүтээгдэхүүнд хяналт тавьж бүртгэлийн дэвтэрт тэмдэглэн зурагжуулан гарал үүслийн гэрчилгээнд хяналт тавин ажиллаа.

Хүүхэд гэр бүл хүчирхийлэлтэй тэмцэх зорилгоор сумын эцэг эхчүүдийн дунд хууль сурталчилах зөвлөгөөн зохион байгуулах

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Хонгор сумын ЗДТГ, 16-р цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, цагдаагийн хэсэг хамтран “Гэр бүл – хүмүүжлийн анхдагч орчин” эцэг эхчүүдийн зөвлөгөөнийг зохион байгуулж 70 эцэг эхчүүд оролцсон. Зөвлөгөөний үеэр зөрчлийн тухай хууль, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн эмхтгэл 60 ш, эцэг эхчүүдэд зориулсан 6 төрлийн тараах материал 250 ш тараасан. Энэ үеэр 16-р цэцэрлэгийн ахлах бүлэг, бэлтгэл бүлгийн хүүхдүүд эцэг эхчүүддээ зориулж мэндчилгээ дэвшүүллээ. Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас 46000 төгрөгийн санхүүжилт хийгдсэн.



Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр хяналт шалгалт хийх



Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Цагдаагийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас зохион байгуулсан "Хуулиа мөрдье 21" сарын аяны хүрээнд сумын хэмжээнд архи худалдан борлуулдаг ААНБ-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж зурагт хуудас нааж, "Хонгор сум Буурал" цахим сүлжээгээр сурталчилж, холбогдох хууль тогтоомжийн талаар зөвлөмж өгч, "Хуулиа мөрдье 21", "Сэрэмжилье нэгдье" хэлэлцүүлэг, Зөрчлийн тухай хууль, Архидан согтууруулахтай тэмцэх тухай хуулийн

талаар өсвөр үе, залуучууд, сумын хамтарсан багийн гишүүдэд сургалт зохион байгууллаа.



Сумын цагдаагийн хэсэг ГБЗХГазар хамтран архины хамааралтай 15 иргэнд архины хэрэглээ, зөрчлийн хуулиар сургалт явуулсан.

Аймгийн засаг даргын захирамжаар сар бүрийн 17 ны өдөр согтууруулах ундаагаар үйлчилгээ үзүүлдэг 9 аж ахуйн нэгж байгууллагад зөвлөмж өгч, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллаж байна.

Аймгийн ИТХ-ын 2018 оны 10/04 дүгээр тогтоолоор батлагдсан "Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох журам" болон 2018.05.25-ны өдөр хийгдэх хяналт шалгалтын удирдамж, хуваарийг архи согтууруулах ундаа худалдан борлуулдан 15 хүнсний дэлгүүрт хүргүүлсэн.



Согтууруулах ундаа худалдан борлуулдаг нийт 16 хүнсний дэлгүүрээс 15 Аймгийн Засаг даргын 2018 оны 01-А/167 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн гүйцэтгэсэн

“Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөлтэй болон зөвшөөрөл авахаар хүсэлт гаргасан аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаанд аттестатилал”-ын шалгалтанд 14 байгууллага аймгийн ИТХ-ын 2018.02.28-ны өдрийн ээлжит бус 10-р хуралдааны 10/04 тогтоолоор баталсан журмын 3.1. дүгээр зүйлд заагдсан тавигдах шаардлагыг бүрэн хангаагүй тул Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу мэдэгдэл хүргүүлж ажилласан.

Зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх анхааруулах самбар байрлуулах /Цайдам орчим малын хөдөлгөөн их байдаг тул мал дайрагдаж зам тээврийн осол их гардаг/

Сумын Буурал багийн Цайдам хэсэгт Олон улсын зам дагуу малтай олон суурьшсан тул мал дайрагдаж хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн хохирол учирдаг тул энэ төрлийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, анхааруулах самбарыг хийж байршууллаа.



Байгаль орчны гэмт хэргээс урьдчилан сэргийлж уул уурхайн аж ахуйн нэгжүүдэд хяналт, шалгалт хийх

Дархан-Уул аймгийн Хонгор сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн 2018 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсны дагуу ИТХ-ын дарга, засаг даргын хамтарсан удирдамжийн хүрээнд тус нутаг дэвсгэрт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагад байгаль орчны хамгаалах хууль, ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа талбайн ашиглалт хамгаалалт, төлбөр ноогдуулалт, газрын гэрээ гэрчилгээ олгох сунгах, зөрчил дутагдлыг шалгах, газрын кадастрын зураглалыг мэдээллийн санд бүртгүүлэх зорилгоор 2018.05.28-ны өдрөөс 2018.05.31-ны өдөр хүртэл хяналт шалгалтыг ИТХ-ын дарга Н.Ганбаатар, Засаг дарга Т.Атархишиг, Засаг даргын орлогч Б.Лхагвасүрэн, БОХУБайцаагч Д.Батхишиг, Татварын улсын байцаагч Г.Дарханбаяр, цагдаагийн хэсгийн төлөөлөгч Д.Баярмагнай, газрын даамал Ц.Базарсад нарын бүрэлдэхүүнтэй хяналт шалгалтыг хийж гүйцэтгэв.

2018 оны 05-р сарын 29-ны өдөр Дархан-Уул аймгийн Хонгор сумын 2-р багийн нутаг Бичиг хад болон Бага ноён гэх газруудаар хяналт шалгалт зохих зөвшөөрөл, холбогдох бичиг баримтгүй үйл ажиллагаа явуулж байсан Дэвжих ногоон монгол ХХК, Төгс байгаль ХХК компанийн үйл ажиллагааг зогсоож дизель станц, 2 тээврийн хэрэгслийг Шарын голын цагдаагийн тасгийн

журмын хашаанд саатуулж, хэргийн материал үүсгэн цагдаагийн байгууллагад шилжүүлсэн.



Бухтын даваа болон хүйтний даваа, могойн зоогоор зөвшөөрөлгүй нэвтрэхийг завдсан 4 экскаватор ачсан тээврийн хэрэгслийг саатуулж бичиг баримтуудыг нь хураан авч буцаан, 1 техникийг шарын гол сумын цагдаагийн тасагт саатуулсан.



2018 оны 05-р сарын 30-31-ны өдөр уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй 5 аж ахуйн нэгж байгууллагуудаар хяналт шалгалт зохион байгуулав.

№	Аж ахуйн нэгж, байгууллага	Эрсдлийн үнэлгээ	Илэрсэн зөрчил	Авсан арга хэмжээ
1	Уулс ноён ХХК	Дунд эрсдэлтэй	Усны дүгнэлт гараагүй хүлээгдэж байгаа.	Хугацаатай зөвлөмж хүргүүлсэн.

2	Газар хэвлий ХХК	2018.07-р сард шалгалтанд хамрагдана.		
3	Монзол ХХК	Үйл ажиллагаа эхлээгүй байгаа. 2018.07-р сард шалгалтанд хамрагдана.		
4	Жел Гор ХХК	Үйл ажиллагаа эхлээгүй байгаа. 2018.07-р сард шалгалтанд хамрагдана		
5	Рич Могол ХХК	Их эрсдэлтэй	Холбогдох бичиг баримт БОАЖЯ, АМГТГазраас хүлээгдэж байгаа. Усны дүгнэлт гараагүй үйл ажиллагаа явуулсан.	3 экскаватор, 2 угаах төхөөрөмжинд лац тавьж үйл ажиллагааг түр зогсоосон.
6	Шенгчан ХХК	Үйл ажиллагаа эхлээгүй байгаа. 2018.07-р сард шалгалтанд хамрагдана		
7	Оргил Сэр ХХК	Үйл ажиллагаа эхлээгүй байсан. 2018.07-р сард шалгалтанд хамрагдана.		
8	Барилга Орд ХХК	Дунд эрсдэлтэй	Олборлолтын үйл ажиллагаа явуулж эхлээгүй байгаа.	2018.07.01 хүртэл хугацаатай зөвлөмж өгсөн.
9	Хааны Харгуй ХХК	-	Уурхайд байх бичиг баримт МХГазарт шалгуулахаар хүргүүлсэн байсан.	Үйл ажиллагааг түр зогсоосон. 2018.07-р сард шалгалтанд хамрагдана.
10	Хөөсгөл ХХК	-	Холбогдох бичиг баримт БОАЖЯ, АМГТГазраас хүлээгдэж байгаа. Үйл ажиллагаа эхлээгүй байгаа.	Хугацаатай зөвлөмж өгсөн.



Хяналт шалгалтын дүгнэлт:

1.Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагуудын уулын ажлын төлөвлөгөө, усны дүгнэлт, нарийвчилсан үнэлгээ гэх мэт бичиг баримтууд төрийн захиргааны байгууллагаас цаг тухайдаа гарахгүй хүндрэл үүсгэж байна. Бичиг баримт гараагүй байхад байгууллагууд олборлолтын үйл ажиллагаа явуулж хууль зөрчих эрсдлүүд үүсэж байна.

2.Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй компаниудын ихэнх нь газрын гэрээ гэрчилгээ байхгүй байгаа нь газрын төлбөр төлөхгүй үйл ажиллагаа явуулах эрсдэл үүсч байгаа тул 2018

оны 07-р сарын 1-ны өдрөөс өмнө сумын засаг даргыг захирамж гаргуулж гэрээ гэрчилгээжүүлэх шаардлагатай байна.

3.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн талбайд мэргэжлийн байгууллагаар цэг тэмдэгжүүлж хатуу цэг байршуулах

4.Уулын ажлын төлөвлөгөөгөөр хуучин олборлолт явуулсан талбайг техникийн нөхөн сэргээлт хийлгэж орон нутаг хүлээн авах шаардлагатай.

5.Гадаадын хөрөнгө оруулалттай байгууллагууд болон гадаад дотоодын ажилчид ажиллуулж байгаа компаниуд ажилласдынхаа бүртгэл мэдээллийг орон нутагт өгч хамтран ажиллах шаардлагатай байна.

Тайланд хийж гүйцэтгэсэн ажилтай холбогдох баримт материалыг хавсаргав.

Хуудас.....

ТАЙЛАН

ХЯНАСАН: СГХУСАЗЗөвлөлийн дарга

Н.Ганбаатар

ГАРГАСАН: СГХУСАЗЗөвлөлийн зохицуулагч

Б.Мөнхбаяр